

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн Байцгаана уу,

Хаврын улирал эхэлж бид олон арга хэмжээ зохион байгуулж завгүй ажиллаж байна. Ойрын хугацаанд зохиогдох зарим арга хэмжээнүүдээс дурдвал:

3 сарын 16-ны 6 цагт Их Дээд сургуулийн элсэлтийн талаар мэдээлэл хийнэ. Монгол, Солонгос хэл дээр орчуулга хийгдэнэ.

11-р ангийн сурагчид ирэх жил элсэн орох сургуулиа сонгож элсэлтийн материал бүрдүүлэх мэдээллээ бэлтгэх цаг ирлээ. Бид 11-р ангийн сурагчдад болон тэдний эцэг эхчүүдэд зориулж 3 сарын 16-ны 6 цагаас их дээд сургуульд элсэх өргөдлийг хэрхэн бэлтгэх талаар мэдээлэл хийх болно. Ахлах ангийн сурагчдын Зөвлөх Jim Larrison АНУ болон Их Британийн их дээд сургуулиудын элсэлт болон манай сурагчдын судалдаг ИВ хөтөлбөр сурагчдын маань элсэлтэнд хэрхэн дэмжлэг үзүүлдэг талаар мэдээлэл өгөх болно. Энэ уулзалт сурагчдыг маань цаашид суралцахад чухал ач холбогдолтой уулзалт байх болно. 3 сарын 16-нд ОУДС-с зохион байгуулах энэ уулзалтын үеэр би та бүхэнтэй уулзаж ярилцана гэж найдаж байна.

3 сарын 17-нд ИВ Дипломын Хөтөлбөрийн талаар 10-р ангийн сурагчид болон тэдний эцэг эхчүүдэд зориулж уулзалт хийнэ. Энэ уулзалтыг бас орчуулгатай хийлгэх талаар бид бодолцож байна. Уулзалтын үеэр Дипломын Хөтөлбөрийг амжилттай судлахын тулд сурагчид юуг анхаарч ямар мэрийлт гаргах талаар мэдээлэл өгөх болно. Та бүхэн уулзалтанд хүрэлцэн ирж дипломын хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл аваарай. Та энэ уулзалтанд ороцлсоноор ИВ дипломын хөтөлбөрийг амжилттай судлахад нь хүүхэддээ хэрхэн туслах талаар бодит мэдээлэл авах болно.

3 сарын 18. 6:00 цагаас Хөнгөн Зууш, Жигнэмэгийн Худалдаа, 7:00 цагт жүжгийн тоглолт эхэлнэ. “Charlie and the Chocolate Factory”- ОУДС-ийн тайзан дээр тоглогдоно. Та бүхэн хүрэлцэн ирж манай жүжгийг сонирхон үзээрэй. Энэ жүжгийг манай бага сургуулийн хамт олон өөрсдийн хүчээр найруулан тавьж байгаа бөгөөд жүжгийн тайз засал, бэлтгэл ажил, хувцас оёх бүх ажлыг манай багш нар өөрсдөө гардан хийсэн. Би та бүхэнтэй манай тоглолтын үеэр уулзана гэж найдаж байна.

3 сарын 22-ны 6:30. Бага Сургуулийн Хөтөлбөр/Сурагчдын удирдах хурлын талаар мэдээлэл хийх уулзалт болно. Сурагчдын удирдах хурлын үеэр сурагчид өөрсдийн сурсан, хийж бүтээсэн зүйлсээ эцэг эхчүүддээ тайлбарладаг. Тэдний сонсогчид нь эцэг эхчүүд нь буюу асран хамгаалагчид нь байдаг. 3 сарын 22-ны орой энэ хурлыг хэрхэн зохион байгуулах үйл явцын талаар та бүхэнд тайлбарлаж мэдээлэл өгөх болно. Сурагчдын удирдах хурал 3 сарын 31-нд болно.

3 сарын 29-с эхлэн бид Номтой Нөхөрлөх 7 хоног зохион байгуулна. Энэ үеэр та бүхэн хүүхдээрээ ном уншуулаарай. Би сургуулийнхаа зарим ангиудаар орж сурагчдад ном уншиж өгнө. ОУДС-с зохион байгуулах эдгээр арга хэмжээнүүдэд ирж оролцоорой гэж би та бүхнийг урьж байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Захирал Greg Rayl

ХУАНЛИД ТЭМДЭГЛЭХ ӨДРҮҮД:

3 сарын 16	ЭББ-ийн хурал Номын санд 3 цагаас
3 сарын 16	Их Дээд Сургуулийн элсэлтийн талаар 11-р ангийн сурагчид, эцэг эхчүүдэд мэдээлэл хийх уулзалт
3 сарын 17	ИВ Дипломын Хөтөлбөрийн талаар 10-р ангийн сурагчид, эцэг эхчүүдэд мэдээлэл хийх уулзалт-6:30
3 сарын 18	Бага Сургуулийн жүжгийн тоглолт 7:00 цагаас
3 сарын 22	Бага Сургуулийн Хөтөлбөр/Сурагчдын удирдах хурлын талаар мэдээлэл өгөх уулзалт 6:30-с Номын Санд
3 сарын 29	Дуртай номынхоо гол баатрын дүрд хувирах өдөр/Номтой Нөхөрлөх 7 хоногт зориулсан өдөрлөг өглөө 8:30-д

Дугуйлангууд: 3 сарын 18-нд Бага Сургуулийн Жүжгийн тоглолттой тул дараах дугуйлангууд энэ

өдөр хичээллэхгүй болсоныг анхаарна уу. Үүнд: Хөвгүүдийн Хөл бөмбөг, Бадминтон, Каратэ, Кино Клуб, Ширээний Теннисний дугуйлан

Драмын дугуйлан, Yearbook, Фото Зураг, Солонгос хэлний зохион бичлэг, Асрамжийн Хүүхдүүдийн Дугуйлангууд тус тус хуваарийн дагуу хичээллэнэ.

Номтой Нөхөрлөх 7 хоног

Read-A-Thon-ы талаарх мэдээлэл бэлтгэл ангиас 12-р анги хүртэлх бүх сурагчдад очсон. Та бүхэн хүүхдүүддээ ном уншихад нь туслаарай. 3 сарын 29-ний Даваа гарагт өөрсдийн дуртай номынхоо гол баатрын дүрээр хувцаслах өдөр байгаа. Та бүхэн хүүхдүүдтэйгээ ямар дүрийн хувцас өмсөх талаар ярилцаарай. 3 сарын 29-ний өглөө 8:30-д сургуулийн өдөрлөгтэй. Энэ үеэр манай сургууль дээр Канадын хүүхдийн зохиолч Margriet Ruurs айлчилна. Эцэг эхчүүд та бүхэн хүрэлцэн ирж манай өдөрлөгт оролцоорой.

Урлагийн Авьяастануудын өдөр-5сарын 21

Урлагийн авьяастнуудын өдрийг бид 5 сарын 21-нд зохион байгуулах гэж байна. Энэ арга хэмжээ бол тэмцээн биш. Сурагчдын авьяасыг тодруулах энэ арга хэмжээнд та бүхэн дуулж, хөгжимдөж, бүжиглэн өөрсдийн авьяаслаг тоглолтоо бидэнд сонирхуулаарай. Сурагчид гоцлол болон хамтарсан тоглолт хийж болох бөгөөд бие даан эцэг эхийн оролцоогүй өөрсдөө тоглолтоо үзүүлэх болно. Нэгдсэн концертод тоглох номерийг сурагчдын авьяас, тоглолтын ур чадвар дээр үндэслэн сонгох болно. Дараагийн долоо хоногийн сүүлээр энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Ms. Leong та бүхэнд хүргэх болно.

ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Мягмар гарагт хичээл эхэлсэн болохоор энэ 7 хоног хурдан өнгөрлөө. Сурагчид хичээлдээ шамдан багш нар маань 3 өдөр амарч цаг агаар дулаарах төлөвтэй байгаад баяртай байна. Гэсэн хэдий ч өвөл арай л дуусаагүй байгаа учир өглөө хичээлдээ явахдаа хүүхдүүд маань дулаан хувцаслаж байгаа эсэх дээр бид анхаарах хэрэгтэй байна. Сүүлийн үед өглөөдөө -25 градус байхад зарим сурагчид малгайгүй, бээлийгүй, өвлийн хүрэмгүй хичээлдээ ирсээр байна. Цаг агаар ийм байхад би дулаан хувцаслах талаар байн байн анхааруулахгүй байж чадахгүй нь. Ямар нэгэн зүйл тохиолдлоо гэхэд тусламж ирэхээс өмнө олон сурагчид маш их даарсан байдалтай байхаар байна.

3 сарын 31-нд болох Сурагчдын Удирдах Хуралд Dave Chilton манай сурагчдыг бэлтгэхээр тэдэнтэй ажиллаж байна. Та бүхэн энэ өдрийг хуанлидаа тэмдэглэж сургууль дээр хүрэлцэн ирж хүүхдүүд тань юу сурч байгаа талаар өөрсдөөс нь шууд сонсоорой.

3 сарын 16-нд 11-р ангийн сурагчид, эцэг эхчүүдэд их сургуулийн элсэлтэнд бэлтгэх талаар, 3 сарын 17-нд IB Дипломын Хөтөлбөрийн талаар 10-р ангийн сурагчид, эцэг эхчүүдэд мэдээлэл хийх уулзалтууд болно. 3 сарын 18-ны Пүрэв гарагт Бага Сургуулийн сурагчид “Charlie and the Chocolate Factory” жүжиг тоглоно. Ирэх долоо хоногт та бүхэнтэй сургууль дээр уулзана гэж найдаж байна.

Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann

Сурагчдын Зөвлөлөөс-Ихрүүдийн Өдөр

3 сарын 19-ний Баасан гарагт Сурагчдын Зөвлөл Ихрүүдийн өдрийг зохион байгуулах гэж байна. Ихрүүдийн өдрөөр 2 сурагч яг ижил хувцаслаж ирэх хэрэгтэй. Та бүхэн нэг найзаа сонгож ижил хувцас өмсөж энэ өдрийг зугаатай өнгөрүүлээрэй.

10-р ангийн сурагчид эцэг эхчүүдэд зориулан

IB Дипломын Хөтөлбөрийн талаар мэдээлэл хийнэ.

3 сарын 17-ны Лхагва гарагийн орой 6:30-д сургуулийн номын санд бид IB дипломын хөтөлбөрийн талаар мэдээлэл хийнэ. 10-р ангийн сурагчдад дипломын хөтөлбөрийн талаар бид танилцуулсан. Тийм учраас бид эцэг эхчүүдэд зориулж энэ мэдээллийг өгөх гэж байна. Та бүхэн энэ уулзалтанд оролцож IB дипломын хөтөлбөрийн талаар мэдээлэл авч, багш нартай ярилцаж судлах хичээлээ сонгоход нь хүүхэддээ туслаарай. Энэ уулзалтын үр дүнд сурагчид ирэх жил судлах хичээлүүдээ болон тухайн хичээлүүдээ ямар түвшинд судлах урьдчилсан сонголтоо хийх болно. 10-р ангийн

сурагчид дипломын хөтөлбөрийн хүрээнд судлах хичээлүүдээ маш нарийн зөв сонгох нь чухал яагаад гэвэл энэ сонголт нь их дээд сургуульд элсэхэд болон цаашдын мэргэжлийн сонголтонд нь шийдвэрлэх нөлөө үзүүлдэг. Ийм учраас бид 10-р ангийн сурагчдын бүх эцэг эхчүүдийг энэ уулзалтанд хүрэлцэн ирж зөв сонголт хийхэд нь хүүхдүүдээ туслахыг уриалж байна.

Дипломын Хөтөлбөрийн Зохицуулагч Tom Jenner

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Charlie and the Chocolate Factory

Жүжиг тоглох хугацаа ойртож манай бага сургуулийн сурагчид Пүрэв гарагийн оройг тэсэн ядан хүлээж байна. Жүжиг тоглох өдөр буюу Пүрэв гарагт Бага сургуулийн сурагчдын дугуйлангууд хичээллэхгүй.

Сурагчид ангидаа орой 6:30 гэхэд бэлэн ирсэн байх ёстой. (6:30-с өмнө хүүхдүүд хоолоо идсэн байх хэрэгтэйг анхаарна уу)

Эцэг эх багш нарын бүлэг хөнгөн зууш, жигнэмэгийн худалдааг 6 цагт эхэлнэ. Хэрвээ сурагчид сургууль дээр 6:30-с өмнө ирэх бол тэд эцэг эхийн хяналтан дор байх ёстой. Эцэг эхчүүд болон зочид 6:50 гэхэд суудлаа эзэлсэн байх хэрэгтэй. Жүжиг 7 цагт эхэлнэ. Энэ жил бид эцэг эхчүүд та бүхнийг суудлаасаа босолгүй сууж жүжгээ үзэхийг хүсэж байна. Зураг авч сурагчдад болон бусад үзэгчдэд саад болохгүй байхыг анхааруулж байна. Та бүхэн мэргэжлийн түвшинд бичсэн DVD бичлэг, фото зурагнуудыг тоглолтын дараа худалдаж авах боломжтой. DVD болон фото зураг захиалах тусгай хуудсыг сурагчдад өгч явуулна. Хэрвээ та бүхэнд асууж лавлах зүйл байвал шууд ангийн багш нартай холбоо барина уу.

3 сарын 31-ний Лхагва гараг-Сурагчдын Удирдах Хурал

Бага сургуулийн эцэг эхчүүдэд зориулж сургуулийн вэб сайт дээр энэ талаар мэдээлэл тависан байгаа. Хэрвээ та бүхэн Интернетэд орох боломжгүй бол хүүхдийнхээ ангийн багштай нь холбоо барина уу. Бид хэвлэмэл хувийг та бүхэнд хүүхдээр тань илгээх болно. Энэ өдөр хичээл орохгүй. Сурагч нэг бүр нэг цаг хагасын хугацаанд эцэг эхдээ өөрсдийн сурсан зүйлс хийсэн бүтээлээ үзүүлж тайлбарлах болно. 3 сарын 15-ны Даваа гарагт хурлын цагийн хуваарийг та бүхэнд явуулах болно.

3-р ангийн сурагчдын Одон Орны Ажиглалтын талаар сурагч Mackenzie Wilson, Iris Estrada нар бичиж байна:

2 сарын 26-ны Баасан гарагт 3-р ангийн сурагчид оройн 7 цагт сургууль дээрээ ирж гадаа одон орны ажиглалт хийсэн. Энэ үеэр бид бүхэн гадаа гарч телескопын тусламжтайгаар од, сарыг ажигладаг юм. Та телескопоор сарыг ажиглавал сарны гадаргууг сайн харах болно. Бид энэ ажиглалтыг хийсэн. Бид Сансар Огторгуйн тухай судалж байгаа болохоор сарны талаар илүү ихийг мэдэж авахыг хүссэн. Бид сансар огторгуйн талаар хийсэн слайдаа эцэг эхчүүддээ үзүүлсэн.

Кафетериягийн талаар:

Бага Сургуулийн зарим сурагчид хичээлийн дараа хоол, ундаа худалдаж авч байгаа талаар бидэнд мэдээлэл ирсэн. Сурагчдын карт ангид нь хадгалагддаг бөгөөд Бага Сургуулийн сурагчид зөвхөн үдийн цайны цагаар хоол худалдаж авах хэрэгтэй. Ихэнх сурагчид хоолны цэснээс хоол сонгохдоо зөв сонголт хийхгүй байгаа нь надад ажиглагдсан. (Жишээ нь зөвхөн нухсан төмс, ундаа, амттан зэргийг сонгож байна) Сурагч нэг бүрийн хоолыг өдөр бүр зохицуулахад хүндрэлтэй учир та бүхэн хүүхдүүдтэйгээ хоолоо зөв сонгох талаар ярилцаарай. Сургуулийн вэб сайтанд хоолны цэсийг тависан байгаа. Сурагчид үндсэн хоол, шөл, салат, бутерброд, амттан, жимс зэргээс өргөн сонголт хийх боломжтой.

Бага Сургуулийн Эрхлэгч Jan Wiggins